



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



2021 оны 8 дугаар сар

INVEST IN MONGOLIA

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ
ДУГААР 07

ОНЦЛОХ САЛБАР: КОВИД-19 ЦАР
ТАХЛЫН ДАРАА **МОНГОЛЫН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ ХААШАА ЧИГЛЭХ ВЭ?**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 4.8 ИХ НАЯДАД
ХҮРЧ **ХАМГИЙН ӨСӨЛТТЭЙ ЖИЛ
БОЛЖ БАЙНА**

МИШЕЛЬ БОРОК: МОНГОЛ БОЛ
АМЬДРАХАД ГАЙХАЛТАЙ ТАЙВАН УЛС

АГУУЛГА

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САИД
ГАДНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРААС
УУЧЛАЛТ ХҮСЛЭЭ**

ОНЦЛОХ ЯРИЛЦЛАГА:
Б.БУЛГАНЧИМЭГ: ГШХО-ТАЙ
ХОЛБООТОЙ ГОМДОЛ МАРГААНЫГ
ЦАХИМААР ХҮЛЭЭН АВДАГ БОЛНО

**“ДАДЛАГАЖИГЧ МЭРГЭЖИЛТЭН
- 2021” ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ**



www.investmongolia.gov.mn

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсад бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье. Мөн Танд зориулж эрхлэн гаргадаг "Invest in Mongolia" эмхэтгэлийн 8 дугаар сарын дугаарыг хүргэж байгаадаа таатай байна.

Бид Ерөнхий сайдын санаачилсан хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шинэчлэлийн хүрээнд "Дадлагажигч мэргэжилтэн-2021" хөтөлбөрийг хөрөнгө оруулалтын чиглэлээр цаашид мэргэших хүсэлтэй оюутан залуусын дунд зарлан хэрэгжүүллээ. Хөтөлбөр нийт 150 гаруй хүсэлт ирснээс 25 залуусыг сонгон авч 2 сарын турш үргэлжилсэн юм. Дадлагажигчид хөтөлбөрийн хүрээнд зургаан багт хуваагдан долоо хоног бүр хөрөнгө оруулалтын хамгаалал, үйлчилгээ, сурталчилгаа чиглэлээр тодорхой даалгавруудыг гүйцэтгэн, үр дүнгээ тайлагнан ажиллалаа. Тэдний хоёр сарын турш гүйцэтгэсэн даалгавар нь бидний ажилд чухал хувь нэмэр оруулсныг онцлон, залуустаа талархал илэрхийлье. Мөн энэхүү 8 дугаар сарын дугаар бол дадлагажигч залуусын бие даан хариуцан гүйцэтгэсэн төгсөлтийн ажил болохыг дуулгахад таатай байна.

Энэхүү товхимолтой холбоотой санал хүсэлтийг манай газрын info@nda.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Үндэсний хөгжлийн газрын хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан дэд дарга

Б.БУЛГАНЧИМЭГ

Та бүхнийг хүндэтгэсэн
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СТАТИСТИК

ГРАФИК 1. ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ / ЖИЛЭЭР /

2021 оны 1-р улирлын байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт 0.71 тэрбумд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 17.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 88 хувийг уул уурхайн салбар, 5 хувийг худалдаа, нийтийн хоол, 2.4 хувийг банк санхүүгийн салбар, үлдсэн хувийг бусад салбар тус тус бүрдүүлж байна.




ГРАФИК 2. ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ

8-р сарын байдлаар нийт экспорт өмнөх сараас 18.7%-иар буюу 885.2 сая ам.доллараар өсч 5626.8 сая ам.долларт хүрсэн бол импорт 16.6%-иар буюу 635.7 сая ам.доллараар өсч 4473.9 сая ам.долларт хүрэв. Гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн сарын мөн үеэс 27.6 хувиар өсч 1152.9 сая ам.долларт хүрсэн байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРГЭН ТОЙРОНД

ҮНДЭСНИЙ ТАВАН ХОРООГ БАЙГУУЛЛАА



бүрдүүлэх, дундаж давхаргыг тэлэх үндэсний хороо

Тус хорооны анхны хурлаар Үндэсний баялгийн сангийн тухай, Нийгмийн даатгалын багц хууль, Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийн танилцуулгыг сонслоо. Мөн Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар “Залуус 1” орон сууцны хорооллын талаар танилцуулжээ.

5. “Олимпизмыг дэлгэрүүлэх, хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх” үндэсний хороо

Тус хорооны анхдугаар хурлаар хүний хөгжлийн үндсэн гурван хэмжигдэхүүн манай улсад ямар түвшин, нөхцөл байдалд байгааг Үндэсний хорооны гишүүд танилцуулав. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хүний хөгжлийн индексийг дээшлүүлэхэд салбарын уялдаа холбоог хангаж ажиллан, нийт хүн амын дунд соёлын эрс өөрчлөлтийг эрчимжүүлэх шаардлагатайг Үндэсний хорооны гишүүдэд даалгалаа.

Эдгээр хороог Монгол Улсын Ерөнхий сайд ахлах бөгөөд бүрэлдэхүүнд нь Засгийн газрын холбогдох гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл багтжээ.

Засгийн газрын 2021 оны наймдугаар сарын 18-ны ээлжит хуралдаанаар, “Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр үндэсний дөрвөн хороог байгуулахаар боллоо. Үүнд:

1. Цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндэсний хороо

Энэ хорооны анхны хуралдааны үеэр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх хуулийн төслийг танилцуулжээ.

2. Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авилгагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хороо

Уг хорооны анхны хуралдаанаар “Хоёр


жилийн дотор авлигын индексийг хоёр оронтой тоо руу оруулах зорилттой ажиллахаа мэдэгдсэн юм. Мөн нийслэлийн дүүргүүдийн газрын албаны үйл ажиллагааны хүнд суртал, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулахтай холбоотой ирж буй гомдол, саналын тухай асуудлын танилцуулгыг сонсож, санал хүсэлт авчээ.

3. Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо

Уг хорооны анхны хуралдаанаар нарийн бичгийн дарга Б.Одсүрэн Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах богино хугацааны 15 шийдлийг Ерөнхий сайдад танилцуулжээ.

4. Иргэдийг орон сууцжуулах, Хуримтлалын нэгдсэн сан, Үндэсний баялгийн сан





e-mongolia шинэчлэгдлээ 2.0

- Цахим бичиг баримт
 - ▶ Эрэлт ихтэй үйлчилгээ
 - ◆ Хиймэл оюун ухаан
 - Хялбар интерфэйс

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “E-MONGOLIA” СИСТЕМИЙН 2.0 ХУВИЛБАРЫГ ИРЭХ 10-Р САРД ТАНИЛЦУУЛНА

Төрийн үйлчилгээний “E-Mongolia” системийн шинэчлэл хийж хоёр дахь хувилбараа энэ оны 10-р сарын 1-ний өдөр танилцуулна. Тус системийн шинэчилсэн хувилбарт дараах таван асуудал оруулж байгаа аж.

1. Монгол Улсын иргэн дунджаар 5-12 бичиг баримттай. Энэ бүх бичиг баримтуудыг оруулж ирсэн
2. Хиймэл оюун ухаан ашиглан өөрт нь

зориулсан үйлчилгээг санал болгоно

3. Хэрэглэгчдэд илүү хялбар ойлгомжтой ашиглахад хялбар болно
4. ААН-үүдэд зориулсан шинэ үйлчилгээнүүд нэвтэрнэ
5. Авлига хүнд сурталтай үйлчилгээг эхэлж цахимжуулна.

Өнгөрсөн онд нээлтээ хийсэн “E-Mongolia” цахим систем нь төрийн 56

байгууллагын 539 үйлчилгээг багтааж өдгөө 1,9 сая хэрэглэгчтэй, 3,3 сая үйлчилгээ үзүүлж, нийт 1,2 сая иргэнд вакцины гэрчилгээ олгожээ. Иргэд төрийн үйлчилгээг цахимаар авснаар төрийн байгууллага руу ирж очих зардал, шаардагдах баримт бичиг бүрдүүлэх зардал, үйлчилгээ авахдаа зарцуулж буй хугацааны зардал зэрэгт 27 тэрбум төгрөг хэмнэсэн гэсэн судалгаа хийжээ.



АВТО ЗАМААР ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ БОЛОН АЧАА ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



“Авто замаар олон улсын зорчигч болон ачаа тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Монгол Улсаас Бүгд Найрамдах Словени Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Г.Баттунгалаг, Бүгд Найрамдах Словени Улсын Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Станислав Рашчан нар 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Любляна хотноо гарын үсэг зурав.

Хоёр улсын эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд авто тээврийн салбарын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй бөгөөд дээрх хэлэлцээрийг байгуулснаар улс хоорондын тээвэрлэлтийн төрөл өргөжиж, Монгол, Словени хооронд шууд тээвэрлэлт үйлдэгдэх, ингэснээр худалдааны эргэлт эрчимтэй өсөх боломж бүрдэж байна.

Монгол, Словени улсуудын худалдааны эргэлт 2020 онд 14,6 сая ам. долларт хүрсэн билээ.

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛНА

“Цар тахлын үеийн эдийн засаг” төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын зөвлөлдөх уулзалт ын үеэр Цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх хуулийг Засгийн газар боловсруулж, УИХ-д өргөн барилаа.. Тус хууль нь:

- Цар тахлын дараах эдийн засгийг эрчимжүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх
- Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай бодлогоор дэмжих

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгаа тэлэх
- Төр, хувийн хэвшлийн цаашдын хамтын ажиллагааг эрчимжүүлж, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилготой.

Уг хорооны анхдугаар хуралдааны үеэр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Цар тахлын дараах эдийн засгийг эрчимжүүлэх амаргүй. Тиймээс хурдтай ажиллах шаардлага үүсэж байна. Засгийн газар байгуулагдаад эхний 200 хоног хүрэхэд хүн амынхаа 60 хувийг вакцины

бүрэн тунд хамруулж чадлаа. Мөн эдийн засгийг сэргээж, хэвийн горимд нь шилжүүлэх зорилт байсан. Бид энэ зорилтдоо хүрч чадсан. Одоо эдийн засгаа эрчимжүүлэхийн тулд Үндэсний хороо байгуулж, салбар бүрийн төлөөллийг оролцууллаа. Тиймээс Цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх хуулийн төсөл боловсруулна” хэмээн онцолж байсан нь ийн ажил хэрэг болж байна. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний хөгжлийн газраас саналаа хүргүүлж ажилласан юм.





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРААС УУЧЛАЛТ ХҮСЛЭЭ

Монгол Улсын шинэ Засгийн газар байгуулагдсан 200 дахь хоногийн босгон дээр “Цар тахлын үеийн эдийн засаг” төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын зөвлөлдөх уулзалт төрийн ордонд боллоо. Энэ хүрээнд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ шинэ Засгийн газрын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг танилцуулсан ба цар тахлын дараах эдийн засгаа сэргээх бодлогыг зарласан. Энэ бодлого нь гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах учир хөрөнгө оруулагчид ихээхэн үүрэг гүйцэтгэх юм.

Цаашдаа Засгийн газар Монголын хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг анхааран ажиллах тул хэрэв Монголын буруугаас болж гадаадын хөрөнгө оруулалтад асуудал тулгарвал хариуцлага хүлээхээ мэдэгдсэн. Энэхүү уулзалтаар Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ: “Өнгөрсөн 30 жилийн хугацаанд хөрөнгө оруулалттай холбоотой болон

тодорхойгүй байсан бүх асуудал дээр Монгол Улсын үе үеийн Засгийн газрыг төлөөлж уучлалт гуйж байна. Өнгөрснөө дүгнэн, шинэ ирээдүйн төлөө Ерөнхий сайдын хувьд өөрөөс шалтгаалах бүх зүйлийг дайчлан, улс орныхоо эдийн засгийг сэргээх тал дээр анхаарч ажиллана. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар нэг цонхоор харж, нэгдмэл байр суурьтай байгааг хэлэх нь зүйтэй. Асуудалд тулга тойрсон байдлаар бус, алсын хараатай ажиллах болно” хэмээв.

Гадаадын хөрөнгө оруулагчдад дэмжлэг, туслалцаа үзүүлэхээр:

- Засгийн газраас зарласан 100 мега төсөлд хөрөнгө оруулагчдыг татах
- Төр, хувийн хэвшлийн уялдаа холбоо сайжруулах, хөрөнгө оруулалтын салбарт тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх боломжоор хангах Үндэсний хороо байгуулах (ингэхдээ Ерөнхий сайд

өөрөө удирдах ба хөрөнгө оруулагчдын төлөөллийн баг байгуулна)

- Цар тахлын дараах эдийн засгийг эрчимжүүлэх, тэр дундаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчноор хангах
- Цаашлаад дээрх хууль батлагдвал гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих төрийн захиргааны төв байгууллага буюу дэргэдээ Гадаадын хөрөнгө оруулалтын агентлагтай Эдийн засгийн хөгжил, төлөвлөлтийн яам байгуулахаар төлөвлөж буйгаа илэрхийллээ.

Энэ дашрамд гадаадын хөрөнгө оруулагчид өөрсдийн санал, бодлоо тусган, хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв.



АХБ-ны суурин төлөөлөгч Павит Рамачандран

“Ерөнхий сайд, та гадаадын хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаар дурдсан. Энэ ажил их чухал гэж бодож байна. Ялангуяа, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгасан хязгаарлалтыг хөнгөлж өгөх нь зүйтэй. Нэн тэргүүнд хамгийн ач холбогдолтой салбарт хөрөнгө оруулалт татах нь чухал. Энэ хүрээнд Засгийн газрын зарласан 100 мега төсөлд хөрөнгө оруулалт татах нь зүйтэй. Эдгээрт хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх гэж байгаа нь туйлын чухал юм. Манай байгууллага энэ чиглэлд Монгол улсын Засгийн газар, Сангийн яам болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллахад бэлэн байна.”

ОУВС-ийн суурин төлөөлөгч Юн Сок Хён

“Цар тахлын дараах эдийн засгийг сэргээх шинэ хуулийн төсөл өргөн барих гэж байгаа нь маш чухал гэдгийг тэмдэглэж хэлмээр байна. Үйлдвэрлэлийн салбарыг урагшлуулахын тулд таны анхаарлыг хоёр зүйлд татмаар байна. Энэ хүрээнд, төрийн хөрөнгө оруулалтын менежмент, мөн зарцуулалтыг сайн хянах нь чухал гэдгийг хэлэх гэсэн юм.”



ДБ-ны суурин төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч Жон Паскал Нгуесса Нгану

“Том амжилт гаргаж байгаа Монгол Улсын Засгийн газарт баяр хүргэмээр байна. Ерөнхий сайд илтгэлдээ дурдсан. Хэрэв вакцинжуулалт, эдийн засгаа сэргээх хөтөлбөрүүд хэрэгжүүлээгүй бол эдийн засаг ямар байх вэ гэдэг нь Ерөнхий сайдын илтгэлд маш ойлгомжтой байна. Эдийн засгаа сэргээх хөтөлбөр хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжүүдэд зээл олгож, бизнес, ажлын байрыг хадгалж чадсан байна. Монгол Улсын Засгийн газартай Дэлхийн банк цаашид хамтран ажиллахад бэлэн байна.”



Бодлого,
зөвлөмж
төлөвлөлтийн
баг

“ДАДЛАГАЖИГЧ МЭРГЭЖИЛТЭН-2021”

ХӨТӨЛБӨР АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Үндэсний хөгжлийн газрын Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсээс 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр “Дадлагажигч мэргэжилтэн хөтөлбөр”-ийг анх удаа зарласан ба нийт 150 анкет хүлээн авч сонгон шалгаруулалт хийлээ. Сонгон шалгаруулалт хоёр өдөр ярилцлага хийсний дүнд

дуусаж эхний шатны сонгон шалгуурлалтад 30 материал тэнцсэн. Шалгаруулалтын дүнд Монгол улсын дотоодын их сургуулиудаас гадна АНУ, Япон, Канад, БНСУ, Итали, БНХАУ, Англи, ХБНГУ улсуудаас санхүү, эдийн засаг болон бусад салбарын мэргэжил, сонирхолтой 25 оюутан залуучууд шалгарсан юм.

Товхимол
гаргах баг

ДАДЛАГЫН ҮЙЛ ЯВЦ ДОЛОО ХОНОГ БҮР СОНИРХОЛТОЙ ДААЛГАВРУУДААР ҮРГЭЛЖЛЭЛЭЭ

Хөтөлбөр нь хоёр үе шаттай явагдсан. Нэгдүгээр үе шатанд, дадлагажигчид нийт зургаан багт хуваагдан долоо хоног бүр хөрөнгө оруулалтын хамгаалал, үйлчилгээ, сурталчилгаа чиглэлээр тодорхой даалгавруудыг хийж зөвлөмж бэлтгэлээ.

Харин хоёрдугаар үе шатанд: Оролцогчид хоёр багт хуваагдан дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

- **Бодлого, зөвлөмж төлөвлөлтийн баг:** Нэгдүгээр үе шатанд багуудын гүйцэтгэсэн даалгавраас гарсан тайланг нэгтгэж Ерөнхий сайдад хүргүүлэх зөвлөмж бэлтгэх ажлуудыг гүйцэтгэлээ.
- **Товхимол гаргах баг:** Наймдугаар сарын товхимлыг англи, монгол хоёр хэл дээр гаргах даалгаврыг гүйцэтгэлээ.
- **Систем хөгжүүлэлтийн баг:** “Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн систем хөгжүүлэх ажлыг гүйцэтгэлээ.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЗОРИУЛСАН СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ

Монгол Улсын Засгийн газраас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг” төслийн хүрээнд “Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн систем хөгжүүлэх ажилд дадлагажигч Д.Амарбаясгалан, Б.Түвшинбаяр, Б.Ариунбат нар статистик мэдээлэл боловсруулах, системийн хөгжүүлэлт хийх, төрийн үйлчилгээний мэдээлэл бэлтгэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн мэдээлэл оруулах зэрэг ажлыг хөтөлбөрийн хүрээнд амжилттай хийж гүйцэтгэлээ.

<http://www.e-invest.mn/> систем нь Гадаадын иргэн харьяатын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Үндэсний хөгжлийн газар, Гаалийн ерөнхий газар, Монголбанк зэрэг газруудтай холбоотой үйлчилгээнүүдийг нэг дор цахимаар үзүүлэх юм. Мөн энэхүү системээс дараах үйлчилгээ авах боломжтой. Үүнд:

- Статистик мэдээлэл авах,
- Цахимаар гомдол гомдол гаргах
- Хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа төслүүдийн албан ёсны мэдээллийг хэрэглэгчдэд хүргэн хөрөнгө оруулалт татах төслийг төсөл хэрэгжүүлэх салбараар, төсөл хэрэгжих бүс, аймаг, хотоор, төслийн төлвөөр ангилан харах боломжтой юм.



Систем хөгжүүлэлтийн баг

ХИЛИЙН ЧИНАДААС ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОРОЛЦОГЧИД



Нэр: Б.Чагдаржав
Сургууль: Ромын Их Сургууль
Түвшин: Бакалавр
Харьяалагдсан баг: Товхимлын баг
Гүйцэтгэсэн ажил: Чех улсын ГШХО-ын судалгаа.



Нэр: Э.Солонго
Сургууль: Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль
Мэргэжил: Нийгмийн ухаан/Докторант
Харьяалагдсан баг: Товхимлын баг
Гүйцэтгэсэн ажил: Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах дэмжих хууль эрх зүйн орчин, төрийн бодлого, эдийн засгийн нөхцөл, өнөөгийн байдал ба онцлог асуудлууд (Япон улсын жишээ).



Нэр: И.Балжинням
Сурч буй сургууль: Итали Улсын Миланы Их Сургууль
Түвшин: Магистр
Мэргэжил: Олон улсын эрх зүй, тогтвортой хөгжил
Харьяалагдсан баг: Хөрөнгө оруулалтын хамгаалалт-2 баг
Гүйцэтгэсэн ажил: Хөрөнгө оруулагчдын гомдол хүлээн авч, шийдвэрлэх SIRM системийг сайжруулах, дүн шинжилгээ хийх.



Нэр: Н.Мөнхтуул
Сурч буй сургууль: University of Edinburgh
Түвшин: Bachelor
Мэргэжил: Economics with Finance
Харьяалагдсан баг: Бодлогын Судалгаа
Хийж гүйцэтгэсэн ажил: Төсөл Чадавхижуулах Хөтөлбөр.



Нэр: Г.Хулан
Сурч буй сургууль: Америкийн Нэгдсэн Улсын Нью Йорк хотын Сиена Коллеж
Түвшин: Бакалавр
Мэргэжил: Улс төр судлал, ОУ-ын харилцаа, эдийн засаг
Харьяалагдсан баг: Товхимлын баг
Гүйцэтгэсэн ажил: БНСУ, БНЧУ Казахстан, Гүрж гэсэн улсуудын олон улсын Investment Council болон SIRM системийн бүтэц болон үйл ажиллагаан дээр харьцуулсан судалгаа анализ хийсэн.

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЭРГЭН ТОЙРОНД

“ДИЖИТАЛ ЭДИЙН ЗАСАГ - ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ”


СЭДЭВТ ЦАХИМ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Үндэсний хөгжлийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар зэрэг байгууллагуудтай хамтран “Дижитал эдийн засаг - Гадаадын шууд хөрөнгө оруулалт” сэдэвт цахим сургалтыг 2021 оны 8 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сургалтаар аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал нь эдийн засаг, тогтвортой хөгжил, гадаадын шууд хөрөнгө оруулалтад хэрхэн нөлөөлж буйг, дэлхийн болон бүс нутгийн нөхцөл байдлын өөрчлөлт, дижитал эдийн засагт Монгол Улс хэрхэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, сурталчлах талаар танилцуулсан.

Сургалтын эхний өдөр буюу 8 дугаар сарын 26-ны өдрийн сургалтыг нээж, НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагч ноён Тапан Мишра, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс Хөрөнгө оруулалт ба аж ахуйн нэгжийн хөгжлийн хэлтсийн дарга ноён Тиентип Субханиж болон Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг нар нээж үг хэлсэн ба нийт 14 байгууллагын төлөөлөл бүхий 75 гаруй зочинтойгоор амжилттай үргэлжиллээ.

Сургалтын 2 дахь өдөр буюу 8 дугаар сарын 27-ны өдрийн сургалтаар аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг сурталчлах шинэ арга барил болох ГШХО 4.0-ийн талаарх ойлголтыг өглөө. Мөн тус сургалтаар оролцогчдыг Монгол Улсын нөхцөл байдал, хэрэгцээ, тэргүүлэх чиглэлд үндэслэн, суурь замын зураглалын төслийг боловсруулахад чиглүүлж, сургалтын дараа энэхүү суурь замын зураглалын төслийг нарийн хөгжүүлэх, ГШХО 4.0 стратегийг боловсруулах талаар хэлэлцлээ.



ОНЦЛОХ ЯРИЛЦЛАГА

Б.БУЛГАНЧИМЭГ: ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГУУДААС СУРАЛЦАН, ГОМДОЛ МАРГААНЫГ WWW.E-INVEST.GOV.MN ХАЯГААР ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭДЭГ БОЛЛОО



Бид товхимлынхоо 8-р сарын онцлох зочноор Үндэсний хөгжлийн газрын гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан дэд дарга Б.Булганчимэгийг урьж тус ажлыг авснаас хойш есөн сарын хугацаанд хийсэн ажлын явц, үр дүнг тодрууллаа.

Үндэсний хөгжлийн газар болон Инвест ин Монголиа багт шинэ удирдлага томилогдсоноос хойших 9 сарын хугацаанд хийсэн хамгийн гол ажлууд юу байв.

Анх ажлаа авахдаа хөрөнгө оруулалтын орчин 4 чиглэлд сайжрах ёстой гэж зорилго тавьсан. Нэгдүгээрт, хууль эрхзүйн орчин одоо байгаагаасаа сайжрах ёстой. Хоёрдугаарт, үйлчилгээ цахимжиж, хэмжиж болохуйц дэвшил иргэдийн авч байгаа үйлчилгээнд гарах ёстой. Гуравдугаарт, хөрөнгө оруулагчдыг хамгаалдаг, гомдол маргааныг шийдвэрлэдэг чадамж манай багт суух ёстой. Дөрөвдүгээрт, хөрөнгө оруулалтыг татах үндэсний хийгээд салбар, салбарын стратегитай байх ёстой, түүн дотроо хөрөнгө оруулалт горилж буй төслүүдийг олон улсын түвшинд нийцэхүйц бэлтгэх чадвартай байх ёстой гэж зорилгоо тодорхойлсон. Ер нь улс орнуудын хөрөнгө оруулалт хариуцсан төрийн байгууллага нь ийм чадавхтай байдгийг баримжаалж тодорхойлсон хэрэг.

9 сарын хугацаанд харин энэ 4 зорилгоо хэр ахиулсан байна бэ гээд үзвэл:

1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл маань олон улсын байгууллагуудын зөвлөмж, улс орнуудын хөрөнгө оруулалт татаж байгаа туршлага дээр нь бидний хөрөнгө оруулагчидтай нэг бүрчлэн уулзаж ярилцага хийн, цуглуулсан гомдол санал дээр үндэслэн амжилттай эцэслэгдэж байна. Энэ намрын чуулганаар оруулах зорилготой ажиллаж байгаа юм.
2. Үйлчилгээний цахимжилт ч мөн маш амжилттай хэрэгжиж өмнө нь төрийн нийт 5 агентлаг дамжин, 15 өдөр зарцуулан байж авдаг байсан үйлчилгээг www.e-invest.gov.mn хаягаар цахимаар нэг дор үзүүлдэг болсон нь амжилт юм. Мэдээж төгс үйлчилгээ болоогүй ч цаашид улам сайжруулж, үйлчлүүлэгчдийн цахим нэг цэгийг бий болгох зорилготой ажиллаж байна.
3. Хөрөнгө оруулагчдын гомдол маргааныг шийдвэрлэж чадахгүйн улмаас үүддэг бодит зардал болоод олон улсад Монгол Улсын нэр хүндэд халдаж мэдэх олон үр дагавар бий.

Олон улсын сайн туршлагуудаас суралцан, гомдол маргааныг www.e-invest.gov.mn хаягаар хүлээн авч шийдвэрлэдэг боллоо. Цаашид энэ үйл ажиллагааг сайжруулж, ҮХГ өөрийн гэсэн мэргэжлийн хийгээд нарийн мэргэшлийн (тухайлбал газар өмчлөлийн, татварын гэх мэт) асуудлаар бэлтгэгдсэн зөвлөх багтай болохоор ажиллаж байна. Олон улсад ийм багийг **home doctors** гэж нэрлэдэг бөгөөд манайд зайлшгүй шаардлагатай нэгж юм.

Энэ хугацаанд “Инвест ин Монголиа” баг хувийн хэвшлийн хийгээд хөрөнгө оруулагчидтай нээлттэй харилцаатай, тэдний гомдлыг сонсоход үргэлж бэлэн гэдгээ харуулж, итгэлийг нь олж ажилласан явдал нь даамжирч болох олон гомдол, маргаанаас сэргийлж чадсан болов уу гэж найдаж байна.

4. Хөрөнгө оруулалт татахад төслүүдийн бэлэн байдлыг хангах тал дээр хамгийн их хүчээ зориулж ажиллалаа. Нэн тэргүүн мега төслүүдийн бэлэн байдлыг хангах, тэр

дундаа төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжиж боломжтой төслүүдийг бэлтгэх тал дээр Азийн хөгжлийн банк мөн байгаль орчинд ээлтэй төслүүдийг бэлтгэн санхүүжилт татах тал дээр Европийн сэргээн босголтын банкттай хамтран ажиллаж байна.

Старт-ап гэгдэх гарааны төслүүдийг чадваржуулах олон хөтөлбөрүүд хувийн хэвшлээс бойжин гарч байгаа нь талархуштай. Төрийн зүгээс тэдний ажлыг давтан хийх гэхээс тэдний ажлыг хэрхэн дэмжиж, өргөжүүлэх вэ гэдэгт анхаарах нь чухал санагддаг. Иймээс эдгээр төслүүдэд зориулан цахим хуудсан дээрээ цэс нэмж, тэднийг “Ирбис Венчурс” компанитай хамтран нэг сар бойжуулан, бэлтгэж ажилласан нь санаснаас их үр дүн өгсөн.

Цаашид төслүүдийг салбар, салбараар нь бэлдэх, эмэгтэй бизнес эрхлэгчдийн болон орон нутгийн төслүүдийг бэлтгэх тал дээр хөтөлбөр боловсруулан ажиллана хэмээн зорьж байна.

ҮХГ-ын зүгээс уул уурхайгаас бусад салбаруудад хөрөнгө оруулалт татахад нэн түрүүнд ямар ажлуудыг хийхээр төвлөж байна вэ?

Салбаруудын хөрөнгө оруулалт татахад бэлэн байдлыг судлан шалгах, түүн дотроо тухайн салбарт ямар стратегиар хөрөнгө оруулалт татахаа шийдэх, төслүүдийг нь бэлтгэх, төслүүдийг нь хариуцсан институцийг урт хугацаанд туштайгаар бэлтгэх ёстой гэж бодож байна. Манай улсад жишээ нь, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт татна гэж олон жил ярьсан ч, энэ салбарт гаргаад сурталчилъя гэхэд олон улсын шалгуурт нийцсэн бэлэн төсөл байхгүй байна. Хариуцсан яамдад нь тухайлсан мэргэжилтэн байгаад шаардлагатай мэдээллийг цаг бүрд нь шинэчилж хамтран ажиллах хэрэгтэй. Мөн салбарт нэгдсэн байдлаар хөрөнгө татъя хэмээн стратеги боловсруулаад ажиллаж байгаа болон олон улсын зээл тусламж, төсвийн хөрөнгө гээд санхүүгийн эх үүсвэрүүд тухайн нэгдсэн зорилго руу чиглэж байх ёстой. Тиймээс, эдгээр олон хүчин зүйлүүдийг сайжруулж, нэг хэмд оруулахаас эхлэх болов уу.

INTERNSHIP PROGRAMME-2021

"INTERNS LEARNING DAY"



Дадлагажигчид Аппрентис шоуны шилдэг оролцогч Н.Анандтай уулзав.

Хөрөнгө оруулалтын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд онцлох ямар зүйл заалтууд оруулахаар ажиллаж байна вэ? Энэ хуулийн хэрэгжилтийг бодитой, шударга байхад хэрхэн анхаарч байгаа вэ?

Нэн тэргүүнд нэг зүйлийг хэлэхэд, аливаа хууль олон нийтийн хэлэлцүүлэгт хангалттай цаг хугацаа олгож байгаасай гэж хүсдэг. Мөн тухайн хуулийг хэрэглэх бүлгийг харгалзан үзэж, шаардлагатай тохиолдолд хоёрдогч хэл рүү орчуулж, түгээж хэлэлцүүлэх нь олон улсын бизнесийн орчны зарчим. Энэхүү хуулийн хэлэлцүүлгийн энэ зарчмуудыг мөрдөн явна гэж найдаж байна.

Хуулийн шинэчлэн найруулахаас өмнө 3 үндсэн асуулыг гаргаж тавьсан:

1. Үнэхээр хууль маань одоогийн байгаа хувилбараар хөрөнгө татахад саад болж байгаа эсэхийг магадлах. Учир нь олон зүйлийн шалтгаан хуульдаа бус хэрэгжилтэндээ байх нь элбэг.
2. Улс орнууд цар тахлын дараах сэргэлтэд зориулан дийлэнх нь хөрөнгө оруулагчдыг татах зоримог дэмжлэгүүдийг санал болгож байгааг тусгах боломжийг судалсан.
3. Хууль батлах нь нэг хэрэг. Хуулийн хэрэгжилтийг хангах институцийн чадавхыг бид давхар бэлдэж байж хуулиа өөрчлөх хэрэгтэй. Түүн дээр нэмээд тэр

институцийн ажиллах зарчим, горим, бусад төрийн байгууллагатай ажиллах уялдааг тодорхойлох.

Хуулийн төсөлд орсон гол өөрчлөлтүүдийг Ерөнхий сайд өөрийн Засгийн газрын 200 дахь хоногоор хийсэн уулзалтаар ерөнхийлөн танилцуулснаас дурдвал:

1. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, дэмжих, төр, хувийн хэвшлийн хэлцлийн механизмыг идэвхжүүлэх, төрийн байгууллага хооронд үүсэж буй чиг үүргийн давхцлыг арилгах;
2. Гомдол, маргаан шийдвэрлэх явцыг хялбаршуулж, төрийн талаас хариуцах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх;
3. Төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагуудын чиг үүргийн давхцлыг арилгах, шалгалтын үйл ажиллагааг хөрөнгө оруулагчид хүндрэл, бэрхшээл учруулахгүй хэлбэрээр зохион байгуулах;
4. Татварын болон татварын бус дэмжлэгийг тодорхой болгох;
5. Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг ялгаварласан заалтуудыг арилгах
6. Дампуурах үешатыг олон улсын стандартад нийцүүлэн журамлах, ингэснээр Монгол Улсад компаниа орхиод гардаг чанаргүй

олон хөрөнгө оруулалтыг цэгцлэх;

7. Зах зээл онилсон дэмжлэг, сурталчилгааг хөгжүүлэх, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газруудын бүтэц, чиг үүрэгт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, дэмжих, сурталчлах дорвитой арга хэмжээ авах талаар үүрэгжүүлэх, тодорхой зохицуулалтыг бий болгох;
8. Хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төв, цахим нэг цонхны үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгож, үйл ажиллагааг тогтворжуулах зэргүүд болно. Эдгээр заалтаас зарим нэн шаардлагатай нь Ерөнхий сайдын санаачилсан Эдийн засгийг сэргээх хуулийн төсөлд багтсан байгаа.

Цаашид манай улсын хөрөнгө оруулалтын орчинд баримтлах бодлого ямар байх бол, ямар түвшинд хүрээсэй гэж та хүсэж байна вэ?

Нэн тэргүүний зорилго бол, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх. Өнгөрсөн жилүүдэд бидэнд туршлага, чадавхын хувьд бүрэн торниж амжаагүй асуудал байсан. Хэрвээ үнэлгээ гэж байдаг бол бидний хөрөнгө оруулалт татах үнэлгээ олон улсын түвшинд тааруухан байна. Бид ойлгомжгүй, олон ааштай, туйлбартай бус байгаа нь урт хугацааны хөрөнгө оруулалт татах нөхцөлийг



Г.Тэмүгэ Дадлагажигчдад өөрийн ажлын арга барилаа хуваалцав.

бүрдүүлж өгөхгүй байгаа юм. Ийм хөрсөн дээр ямар ч сайхан сурталчилгаа хийгээд, ямар ч нөөц баялаг дээр суурилсан төслүүд байгаад нэмэргүй байна. Тиймээс хамгийн чухал урьдач нөхцөл болсон хууль эрх зүйн орчноо сайжруулаад авбал итгэл олох, нэр хүндээ сэргээхэд нэг алхам ойртоно.

Хоёрдугаарт, шинээр хөрөнгө татах боломжийг бүрдүүлэх. Хөрөнгө оруулалтыг дэмжих замаар мега төслүүдийг санхүүжүүлэх боломж үүсгэн, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ татварын орлого нэмэгдэн, бодлогын дунд, урт хугацааны баримт бичгүүдийн зорилтод хүрэх боломж бүрдэнэ. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хооронд хөрөнгө оруулалтын нөхцөлд ялгамжтай бус, эрх тэгш зохицуулалт бий болгон, гомдол, маргаан шийдвэрлэх чадамжийг олон улсын түвшинд хүргэснээр хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэн, улмаар эдийн засгийн солонгоруулах боломж бүрдэнэ.

Цаашлаад уул уурхайгаас бусад салбарт жижиг, дунд бизнест хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн дэмжлэг авах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутагтай хамтран ажиллах, ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн салбараас бусад салбарыг

хөгжүүлэх, импортыг орлох үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд бодит хувь нэмэр үзүүлнэ. Нөгөө талаасаа манай төслүүд хөрөнгө оруулалтад бэлэн байх нь чухал ажил болно, гэхдээ энэ талаар ажлууд хийгдэж байгаа тул хамтдаа цэгцрээд явах болов уу. Хамгийн чухал нь сайн хууль боловсруулахаас гадна хэрэгжилт байдаг. Тиймээс хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалт, дэмжлэгээр ажиллаж буй хүний нөөц маань өндөр чадвартай байх шаардлагатай. Үүн дээр шат дараалсан арга хэмжээ авна. Түүнээс гадна хөрөнгө оруулалт татахын тулд нийгмийн аль ч шатанд энэ асуудлын мөн чанарыг ойлгодог, ухамсарладаг, дэмждэг байж урагшилна гэдгийг бид ойлгох ёстой.

Сүүлийн асуулт. Та энэ жил Үндэсний хөгжлийн газрын Хөрөнгө оруулалтын бодлого, сурталчилгаа хариуцсан хэлтэст "Дадлагажигч мэргэжилтэн хөтөлбөр"-ийг зарласан. Энэ сэтгүүлийн энэхүү дугаар бол бидний хөтөлбөрийн сүүлийн даалгавар. Та яагаад энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж гэж шийдсэн бэ? Үр дүн ямар байсан гэж дүгнэж байна?

Үр дүн ямар байсныг та нар сайн хариулах байх. Та нар бол энэ зуны хоёр сарын турш үнэт цагаа зарцуулан ажилласан баг шүү дээ. Та бүгдэд өгөөжтэй зун байсан гэдэгт итгэлтэй байна. Бүх өгсөн тайлангуудыг чинь би уншдаг.

Эхнээсээ зарим ажил нь манайд ажил хэрэг болоод эхэлсэн байгаа.

Ер нь хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын орчинд нарийн мэргэшсэн хүний нөөц дутмаг. Та нар энэ эрчээ алдахгүй байж тэр орон зайг нөхөх сэдлээ энэ туршлагаас олж авсан болов уу гэж найдаж байна. Мөн дунд нь 2 удаа та нарын сонгосон олны танил хүмүүсийг урьж ярилцаж, залуу мэргэжилтний өмнө тулгардаг бэрхшээл сорилыг ярьсандаа баяртай байгаа. Та нарыг сонсож би болон манай баг суралцаж байлаа.

Ер нь олон хэвшмэл бэрхшээлийг жаахан ур ухаан, бүтээлч сэтгэл гаргахад шийдчихэж болохын жишээ нь энэ хөтөлбөр байсан гэж боддог. Олон улсын байгууллагад байдаг шиг "Залуу мэргэжилтний хөтөлбөр" төрийн албанд байгаасай, бүр цаашлаад ижил чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын мэргэжилтнүүд 3 жилээр сэлгэн ажиллах горимтой болоосой гэж боддог. Тэгвэл нэг газраа удаад, хэвшмэл сэтгэлгээнд орох, ажлаасаа уйдах, бүтээмж муудах зэрэг сорилын нэг шийдэл байж болох юм.

Танд баярлалаа.

Үнэт цагаа зарцуулан манайд дадлага хийсэн та бүхэндээ баярлалаа.

ЭНЭ САРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

НАМАР ЦАГ: УРГАЦ ХУРААЛТ

2021 ОН УРГАЦ ТАРИАЛАЛТ, ХУРААЛТ

НИЙТ
626.6 МЯНГА ГА ТАЛБАЙД

ҮР ТАРИА
416.8 МЯНГА ГА ТАЛБАЙД

ТӨМС
19.1 МЯНГА ГА ТАЛБАЙД

ЖИМС
4.7 МЯНГА ГА ТАЛБАЙД

ТОСНЫ УРГАМАЛ
80.0 МЯНГА ГА ТАЛБАЙД


Манай улсад тэртээ 1959 оноос эхлэн газар тариаланг хөгжүүлэх замаар хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн хөгжлийг хурдасгах зорилгоор Атрын аяныг зохион байгуулж байсан. Тухайн үед залуучуудыг “Илгээлтийн Эзэд”-ээр томилон газар тариалангийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж олгодог байсан нь энэ аяны нэгээхэн онцлог байв.

Харин 2021.08.03-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас “Илгээлтийн Эзэд” аяныг

эхлүүлж МСҮТ, их дээд сургуулийн оюутнууд, цэргийн алба хаагчид, ажил хайж буй иргэд болон аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ургац хураалтад мөнгөн урамшуулалтайгаар хамруулах, нийтээр оролцох чиглэлээр тогтоол гаргалаа.

Манай улс энэ онд нийт 616 мянга га талбайд үр тариа тарьжээ. Үүний 416.8 мянга га талбайд улаан буудай, 19.1 мянган га талбайд төмс, 9.4 мянган га талбайд хүнсний ногоо, 80 га талбайд тосны ургамал, 4.7 мянган га талбайд жимс жимсгэнэ тариалсан байна.

ГРАФИК 3. НИЙТ ХУРААСАН УРГАЦ УЛСЫН ДҮН (ТН)



ЭХ СУРВАЛЖ: ҮСХ



ТОКИО-2020 ТОЙМ: МОНГОЛ УЛС

Цар тахлын улмаас бүтэн жил хойшлогдсон зуны олимпын XXXII наадам "Токио-2020" 7-р сарын 23-наас 8-р сарын 8-ны өдрүүдэд анх удаа цөөн үзэгчтэйгээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Монгол улсын баг "Токио-2020" олимпод нийт 43 тамирчдын бүрэлдэхүүнтэй оролцсон бөгөөд үүний 60 хувь буюу 25 нь эмэгтэй тамирчид байв. Түүнчлэн манай улс энэ удаа нэг мөнгө, гурван хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 71-р байранд жагссан амжилт үзүүлээ.



АНХНЫ БАГИЙН СПОРТЫН ТӨРӨЛ: ЗХЗ ЭМЭГТЭЙ САГСАН БӨМБӨГИЙН ЭМЭГТЭЙ БАГ

"Токио-2020" олимпод дэлхийн долоон тэрбум гаруй хүмүүсээс шалгарсан жаран дөрвөн шилдэг сагсчид ЗхЗ сагсан бөмбөгийн төрөлд өрсөлджээ. Монголын ЗхЗ сагсан бөмбөгийн эмэгтэй баг нь багийн тэмцээнд анх удаа эх орноо төлөөлөн олимпод оролцсон билээ. Манай тамирчдыг олон улсын хэвлэлүүд "ердөө дөрөвхөн жилийн дотор олимпын эрх авч олон улсад чансаагаа гайхуулна гэдэг бол том амжилт" хэмээн онцолж байлаа. Тэд олимпын тоглолтууддаа АНУ, Япон зэрэг улсын багтай өрсөлдсөн. Мөн ЗхЗ-ийн эмэгтэй сагсан бөмбөгийн тоглогч О.Хулан нь нээлтийн ёслолын үеэр улсаа төлөөлсөн анхны эмэгтэй тугч болсон юм.

АНХНЫ ГАДААДААС ИРГЭНШИЛ АВСАН ТАМИРЧИН: САИД МОЛЛАЙ

Саид Моллей нь 81 кг-ийн жинд чансаагаараа дэлхийд нэгдүгээрт эрэмбэлэгдэж байгаа тамирчин юм. Израиль улстай дайсагнадаг Ираны эрх баригчид Моллейг Израиль бөхтэй барилдуулахгүйн тулд өмнөх барилдаандаа зориуд ялагдахыг шаардсан билээ. Иймд

Моллей Монгол Улсын иргэншилтэй болж "Токио 2020 зуны олимпд Монгол орныг төлөөлөн оролцож мөнгөн медаль хүртсэн юм. Улмаар Монголын тугийг Токиогийн тэнгэрт мандуулсан жудоч, дэлхийн аварга Саид Моллейд Монгол улсын ард иргэд баярласан талархсан сэтгэлээ харамгүй илэрхийлсээр байгаа билээ.

МИШЭЭЛ АМАЗОНКА

Michel&Amazonka брэндийг эгч дүү дизайнер болох Чойгаалаагийн Янжиндулам (Michel), Нямханд (Amazonka) нар 2013 онд үүсгэн байгуулсан юм. Өнгөрсөн 2019 онд Монгол Улсын Засгийн газраас "Монгол брэнд" үүсгэх, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зорилтыг хэрэгжүүлэхээр 59 дүгээр тогтоол баталсан билээ. Улмаар Монгол Улсын үндэсний шигшээ баг, тамирчдаар дамжуулан үндэсний өв уламжлал, соёл, хөгжил дэвшлийг илэрхийлсэн брэнд өнгө төрхийг тодорхойлохоор загварын уралдаан зарлаж, сонгон шалгаруулалт явуулсан. Энэхүү спортын болон ёслолын хувцасны загварын уралдаанд нийт 10 загвар зохион бүтээгч бүтээлээ ирүүлснээс "Мишээл-Амазонка" ХХК-ийн ирүүлсэн загвар шалгарчээ. Улмаар тус компани олимпын нээлт, хаалтын ёслолын

болон спортын хувцас үйлдвэрлэх эрх авсан. Тэдний бүтээлийн талаарх маш олон эерэг сэтгэгдлүүд олимпын нээлтийн дараа цахим орчинд түгсэн билээ.

ПАРАЛИМПИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Монголчууд энэ удаагийн паралимпын наадамд буудлага, байт харваа, хүндийн өргөлт, тэквондо, жудо, хөнгөн атлетик гэсэн спортын зургаан төрөлд 11 тамирчны бүрэлдэхүүнтэй оролцлоо. "Токио-2020" паралимпын наадамд оролцож буй Монголын тамирчид медалийн буухиагаа алтаар эхлүүлсэн юм.

ОЛИМПИЙН ТЭНГЭРТ МОНГОЛЫН ТУГИЙГ МАНДУУЛСАН Э.СОДНОМПИЛЖЭЭ

Энхбаярын Содномпилжээ хүндийн өргөлтийн төрөлд алт медаль хүртэж улсынхаа далбааг Токиогийн тэнгэрт мандуулж, төрийн дууллаа эгшиглүүлээ. 107 кг-ийн жинд бяр чадлаа сорьсон төрбээр хоёр дахь оролдлогоороо 245 кг-ийг өргөж, паралимпын дээд амжилтыг шинэчлэн тогтоосон билээ. Улмаар Монголын баг медалийн хүснэгтийн 42-р байрт бичигдсэн юм.

МАНАЙ УЛСЫН ТЭРГҮҮЛЭХ САЛБАРЧУДЫН МЭДЭЭЛЭЛ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ: КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ДАРАА МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ЯМАР ӨӨРЧЛӨЛТ ГАРАХ ВЭ?

Бид Ковид-19 цар тахлын дараа Монголын аялал жуулчлалын салбарт ямар өөрчлөлт гарах талаар МУИС-ийн аялал жуулчлалын менежментийн тэнхмийн дэд профессор, Британийн Шеффилд Халламын их сургуулийн доктор судлаач Д.Амартүвшинтэй ярилцлаа.

Та бүхний хийсэн судалгааны үр дүнг харж байгааг аялал жуулчлалын салбар Ковид-19 цар тахлын нөлөөгөөр их хохирол амссан салбар байгаа нь харагдаж байна. Тэгэхээр бид цаашид яах ёстой вэ?

Салбараа дахин сэргээхийн тулд төр засгаас гаргаж байгаа цар тахлын үеийн хариу арга хэмжээ, бодлого зөвлөмжүүдээ гадаадын иргэдэд маш тодорхой, хүртээмжтэй болгох нь хамгийн энгийн алхам болох болов уу. Гаднын улс орнуудын туршлагаас харахад хөнгөлөлттэй зээлүүд олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, татвараас хөнгөлөх, урсгал зардлуудыг тэглэх гэх мэт арга хэмжээ авч байна. Манай улс ч мөн адил тодорхой хэмжээний арга хэмжээ авсан. Харин гаднаас жуулчин авах тухайд зарим орнууд улсуудыг эрсдлийн бүсээр ангилан цар тахлын дэгдэлт багатай газруудаас жуулчин авч эхлэх замаар салбараа дэмжиж байна. Мөн “Нөхцөл байдал сайжирхаар ирээрэй” гэдэг сурталчилгааг урлаг, соёлоороо дамжуулан хийж байна.

Хил хаасан үед дотоодын аялал жуулчлал салбарыг сэргэхэд нөлөө үзүүлж чадах болов уу?

Гэр баазуудын хувьд дотоодын аялагчдад чиглэсэн шинэ зах зээлрүү хандаж тодорхой хэмжээний орлоготой байна гэдэг мэдээллүүд байна. Гэхдээ 2020 онд бидний хийсэн дотоодын аялал жуулчлалын судалгаанаас үзвэл дотоодын аялагчдын 96 хувь нь эх орноороо аялахдаа жуулчны компаниар үйлчлүүлэхгүй гэсэн хариултыг өгсөн байсан. Энэ хандлага бол дэлхийн бүхий л орны аялагчдад нийтлэг ажиглагддаг зүйл. Хүмүүс эх орноороо аялахдаа хэлний бэрхшээл, газар орон мэдэхгүй гэх зэрэг асуудал үүсэх нь бага байдаг тул хувиараа аялах нь зардлын хувьд илүү хямд тусна гэж үздэг хандлагатай. Тэгэхээр энэ

баримтаас харж байгаагаар дотоодын аялагчид цар тахлын дараах салбарын сэргэлтэд тийм ч их нөлөөлөхгүй хэмээн харж байна.

Ковидын дараа Монголын аялал жуулчлалын салбарт ямар өөрчлөлт гарах вэ?

Ойрын жилүүдэд Ковид-19 цар тахлаас гадна уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгалийн гамшиг хүн төрөлхтнийг өмнөө сөхрүүлж байгааг бид бүхэн харж байна. Үүний шалтгаан бол хүмүүс

байгаль дэлхийтэй харьцахдаа зөвхөн өөрсдийнхөө эрх ашгийг нэн тэргүүнд тавьснаас үүдэлтэй гэдгийг олон эрдэмтдийн судалгаа батлаад байгаа. Үүнээс улбаатайгаар Ковидын дараа Монголд төдийгүй дэлхийд хүрээлэн буй орчинд хамгийн ээлтэй, эко аялал жуулчлал тренд болно гэдэгт итгэлтэй байна. Дэлхий нийтээрээ зэрлэг амьтны оршин тогтнох орчныг сүйтгэхгүй, хог хаягдал багатай илүү хариуцлагатай, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн аяллыг бий болгохыг зорих байх.

Тэгвэл таны бодлоор Монголын аялал жуулчлалыг дэлхийд төлөөлж чадах зүйл юу вэ?

Монголын аялал жуулчлал өөрөө зүгээр л унаган төрхөөрөө байгаа байгаль юм. Биднийг дэлхийд төлөөлөх хамгийн гол зүйл бол нүүдлийн соёл. Бид хүн бол байгалийн шимийг хүртэж амьдардаг учраас эх дэлхийгээ хайрлаж амьдрах ёстой гэсэн үзэл баримтлалд итгэж амьдардаг ард түмэн. Монголчуудын дунд хүн оршуулахдаа хүртэл газар ухахгүйгээр байгальд нь онголдог соёл ч бий. Усанд бохир зүйл хийдэггүй, газар хөнддөггүй. Тэгэхээр бид нүүдэлчдийн суурь философио аялал жуулчлалтайгаа холбож уламжлалт соёлоо орчин үетэйгээ уялдуулах нь хамгийн чухал гэж боддог. Тал нутгийн салхи, бороо, байгалийн үнэр, хязгааргүй уудам талд морьтойгоо давхиж байгаа хүн, тал дүүрэн бэлчиж буй мал, энгийн нэг малчны гэр бол Монголын аялал жуулчлалыг хамгийн сайн төлөөлж чадах, хамгийн ирээдүйтэй дүр төрх юм.

КОВИД-19 ЦАР ТАХАЛ МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХЭРХЭН НӨЛӨӨЛӨВ?

2021 оны судалгааны дүн

↓ **420 САЯ АМ.ДОЛЛАР**

2019 онд МУ-ын ДНБ-ий 4%-ийг бүрдүүлж чаддаг байсан бол 2020 онд цар тахлын улмаас 425 гаруй сая ам.долларын алдагдал хүлээв.

↓ **88%**

Судалгаанд хамрагдсан аялал жуулчлалын байгууллагын 90-ээс дээш хувийн орлого 88% буурсан.

54%

Байгууллагуудын 54 хувь нь орон тооны цомхотгол хийсэн.

84%

2021 оны 6-р сар гэхэд тэдний 84 хувь нь ажилчдаа үргэлжлүүлэн цалинжуулах боломжгүй болсон.

Эх сурвалж: МАЖХ-ны захиалгаар МУИС болон ШУ-ны академийн багш, судлаачдын хамтран хийсэн судалгаа, 2021

10%

Тэдний 10 хувь нь л ирэх 12-р сар хүртэл ажилчдаа цалинжуулах боломжтой.

Харин Ковидоос өмнө



УУЛ УУРХАЙН САЛВАРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ 2.5 ИХ НАЯДЫН ОРЛОГЫГ ТӨВЛӨРҮҮЛЖЭЭ

Дэлхий дахинд цар тахлын дараагаар эдийн засаг сэргэж буй тул уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсжээ. Зэсийн үнээс жишээ авахад 2020 эхний улиралд 4,700 орчим ам.доллар байсан бол 2021 оны наймдугаар сарын байдлаар 9,440 ам.долларт хүрэв. Энэ оны эхний 6 сарын байдлаар эрдэс баялгийн салбараас улсын төсөвт 2.5 их наядын орлогыг төвлөрүүлжээ.

Нийт экспорт оны эхний 7 сарын байдлаар 4,741.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 953.0 сая ам.доллар буюу 25.2 хувиар өссөн. Үүнээс, эрдэс бүтээгдэхүүний экспорт 4,274.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 693.9 сая ам.доллар буюу 19.4 хувиар өсжээ.

Ташрамд дурдахад,

"Mongolia Mining-2021" гэх уул уурхай, газрын тосны олон улсын үзэсгэлэн энэ оны 9 дүгээр сарын 22-24-нд Улаанбаатар хотноо "Буянт-Ухаа" цогцолборт болохоор болжээ. Уул уурхайн салбар дахь шинэ шийдэл, дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмж, техникийг танилцуулдаг тус үзэсгэлэн энэ удаа 10 дахь жилдээ болох юм. Энэ жил тогтмол оролцогч түнш орнууд болох Австрали, Беларусь, Казахстан, Швед, Герман, Япон, ОХУ болон Канадын компаниуд багтсан 200 гаруй ААН оролцох аж.



ТЭЭВЭР ЛОЖИСТИК



DHL Монгол болон БНАСАУ дахь салбар хариуцсан Зөвлөх Э.Мягмарцогттой цар тахлын үед Монголын тээвэр, логистик компаниудад ямар бэрхшээл тулгарсан, үүнд ямар хариу арга хэмжээ авсан тухай ярилцлаа.

Тээвэр, логистик компанийн онцлог тал болон тээвэр логистикийн компаниудад тулгардаг ямар бэрхшээлүүд байдаг вэ?

Хүндрэл бэрхшээл гэвэл,

- Монгол улс алслагдсан байрлалд байдаг учраас тээвэр логистикийн үнэ болон зардал өндөр байдаг.
- Манай агаарын ачаа тээврийн логистикийн компаниудын хувьд агаарын тээвэр либералчлагдаагүйн улмаас үнэ өндөр болдог нь том асуудал байдаг.

Үүний улмаас Монголд экспорт, импорт үнэтэй тусдаг учраас дотоодын үйлдвэрлэл хөгжихөд хүндрэлтэй байдаг.

Боломж, давуу талын хувьд, манай "DHL Mongolia" компани нь олон улсын буухиа шуудан буюу агаарын шуудан илгээмжийн үйлчилгээ явуулдаг. Хэрвээ агаарын тээврийн салбарыг либералчилж чадах юм бол манай улсын хувьд зардал их хэмжээгээр багасана. Жишээлбэл, Монгол Улстай хамгийн ойр ачаа транзит хийх боломжтой гол боомт нь Сөүлийн Инcheon юм. Тэнд одоогоор ердөө 2-3 компанид зөвшөөрөл олгосон байна. Үүнийг хэрвээ либералчлах юм бол тийшээ очих зорчигчийн болон ачааны урсгал нэмэгдэхээс гадна зардал багасгах боломжууд байдаг. Далайд гарцгүй орон учраас агаарын тээвэр манай улсад маш чухал.

Монгол Улсын хувьд таны хэлж байгаа шиг либералчилсан болохын тулд юу хийвэл зохистой вэ, ямар дэмжлэг, үе шатууд хэрэгтэй вэ?

Энэ тал дээр бизнес эрхэлж буй бид нарын ойлголтоор үндэсний агаарын тээвэрлэгчийн бизнесийг хэт олон компанид алдахгүй гэдэг стратегитай холбоотой болов уу. Жишээлбэл, Инcheonоос маш олон хямд үнэтэй, үйлчилгээ сайтай компаниуд орж ирнэ. Хүмүүс жишээ нь ихэвчлэн дотоодынхоо агаарын тээвэрлэгч нарыг сонгохгүйгээр бусад компаниудыг сонгоод дотоодын агаарын тээвэрлэгч компани нарт хүнд тусна гэдэг шалтгаан байдаг юм болов уу гэж бид нар ойлгож байгаа. Гэтэл эсрэгээрээ манай улсад хөдөлмөр, ажиллах хүчнээс өгсүүлээд зарим

зардлууд бага байдаг. Үүнийг үр ашигтайгаар, зөв өрсөлдөөнд нь оруулаад, өөрсдийнхөө дотоодынхоо компаниудыг хөгжүүлэх талаас бодохгүйгээр шууд өрсөлдөгч нарыг оруулахгүй гээд хаалт тавьчихсан нь дутагдалтай шийдвэр байсан болов уу.

Цар тахлаас үүдэн гарсан бэрхшээлээдээ танай компанид ачаа тээвэр зохицуулах, тэдгээрийг цаг тухайд нь хүргэх хүрээнд ямар асуудлууд гарав? Үүнийг хэрхэн шийдвэрлэсэн бэ?

Цар тахлаас үүссэн хүндрэл бэрхшээл:

1. Монгол улс ямар ч нислэггүй болсон. Дараа нь Хятадаас эхлээд манай бүх шуудан илгээмжээ Солонгос улсын Инcheon боомтоор дамжуулж авдаг болсон ч Солонгосын нислэгүүд мөн зогссон.
2. Тэрний дараа бид Франкфурт болон Берлинээр нислэг хэвийн байх үед Монголын бүх шуудан илгээмж Берлин болон Франкфуртээр дамжина гэсэн үүднээс бид шууд илгээмжээ Европ руу төвлөрүүлсэн. Сүүлдээ бүх агаарын хил хаагдахад, тэр хооронд нэг хэсэг хэцүү байдалтай байлаа.

Үүнийг шийдэхийн тулд:

"Эзинис Эйрвэйз", "МИАТ", Солонгосын "Аир Инcheon" компаниудтай ярилцаад хэд хэдэн удаа DHL олон улсын буухиа шуудан өөрсдөө онгоц захиалж авсан. Хэдий тэд нар илүү үнэтэй байсан болов ч хэрэглэгч нарынхаа өмнө хүлээсэн үүргээ тасалдуулахгүйн тулд энэхүү хэцүү аргыг тухайн үед авч ажилласан. Мөн "Миат" компанитай хамтраад Инcheon руу байнгын зорчигчийн онгоцоор зөвхөн ачаа тээвэрлэх нислэгтэй болоход хоёр талдаа ашигтай болж байна. 3-р улирлаас эхлээд байнгын нислэг тогтмолжоод өнөөдрийг хүртэл долоо хоногт нэг, хоёр нислэгтэй явлаа. Өөр нөлөө гэвэл хоёроос гурван хоногт хүргэгддэг байсан ачаанууд долоо хоног хүртэл Инcheon дээр дараагийнхаа нислэгийг хүлээх асуудал гарсан. Гэхдээ байж болох хамгийн хурдан шуурхай үйлчилгээг үзүүлж чадаж байгаа.

Цар тахлын үеэр танай байгууллага ажилчдынхаа аюулгүй байдал, үр бүтээмж, үйлчилгээний чанараа хэрхэн сайн хангасан бэ? Одоогийн байдлаар танай компанийн өдөр тутам санаа зовних эсвэл шийдвэрлэх асуудлууд юу байна?



ЭМЯ болон УОК-оос гаргасан халдвар хамгааллын зөвлөмжийн дагуу ажилчдынхаа аюулгүй байдалд анхаарсан. 2020 онд олон улсын буухиа шуудангийн хувьд байгууллагын ачаанууд тодорхой хэмжээгээр багассан боловч, хил хааснаас болоод хувь хүмүүс шуудан илгээмжээ явуулах нь ихэссэн. Мөн хаяглалтын тодорхой бус асуудлуудтай цар тахлын дараагаар маш их тулгарч эхэлсэн. Тэрэнтэй холбоотойгоор бид хүргэлтээс өмнө үйлчлүүлэгч нартайгаа нэг, нэгээр нь утсаар холбогдох биш илүү өөр аргаар яаж харилцах уу, хүргэлтийн цагийг хэрхэн урьдчилан тохирч амжилтгүй хүргэлтийг багасгах уу гэх мэтчилэн зүйлс дээр шинэчлэлтүүдийг хийж ажилласан байгаа. Мөн өөр нэгэн бэрхшээл нь цар тахлаас болж манай 24 цагийн үйлчилгээтэй агаарын боомт шууд илгээмжид огт гар хүрэхгүй 14 хоног нисэх дээр хадгална гэсэн шийдвэр гарсан ч хэд хоногийн дараа энэ шийдвэр нь цуцлагдан гурван хоног болж, сүүлдээ нэг хоног болсон. Шийдвэр гаргагч хүмүүсийн хувьд ч цар тахлаас үүдсэн тухайн нөхцөл байдал шинэ зүйлс байсан болохоор ийм асуудлууд гарсан.

Цар тахлын дараа эсвэл энэ үеэр танай компани ямар шинэлэг зүйлсийг байгууллагадаа нэвтрүүлэв? Ирээдүйн үйл ажиллагааг та хэрхэн харж байна?

Өмнө нь илгээмж ирэх үед чиглэлд нь хуваарилаад, чиглэлийн түгээгчээр тэр дор нь хүргэдэг байсан бол хувь хүний гэрийн хаягаар илгээмж маш их ирдэг болсон. Гэрийн хаягаар илгээмж очиход хүн нь гэртээ байхгүй байх магадлал 60 хувь байдаг. Энэ нь зөвхөн Монголд биш дэлхий даяар байдаг асуудал. Үүнээс болж бид харилцан тохиролцох ажлыг хийхийн тулд хүн бүртэй утсаар холбогдох ажлууд хийдэг.

Цаг заваа гарган ярилцсанд танд баярлалаа.

Баярлалаа.

ХӨНГӨН ҮЙЛДВЭР



ЭКО БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР ТОДОРЧ БҮЙ "ДУЛААН СЭТГЭЛ" БРЭНД

Хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж Франц, Япон, Швейцарь улсад бүтээгдэхүүнээ нийлүүлж, хэрэглэгчдийн таашаалд нийцсэн "Дулаан сэтгэл" брэндийг онцлолоо.

- 2014 онд Франц улсын нэгэн гэр бүл манай улсаар аялж тал нутгийн сайхныг бишрэн буцахдаа гэр бүлийнхэндээ бэлэглэхээр ноос, хөөврөн бүтээгдэхүүн худалдан авчээ. Монгол сарлагийн хөөврөн бүтээгдэхүүний дулаахан, зөөлөн чанарыг гайхан дурлахдаа тэд нутгийнхаа өмнөд мужийн бяцхан дэлгүүрт Монгол бүтээгдэхүүн зарах санаа

FAST FASHION VS САРЛАГИЙН ХӨӨВӨР

Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын нөлөө хурдацтай тархан дэлхийн оршин суугч бүр байгальд ээлтэй амьдралын хэв маягийг эрхэмлэх шаардлагатай байгаа өнөө үед дэлхийн хог хаягдлын томоохон эх үүсвэр болсон "fast fashion"-ээс аль болох татгалзах хэрэгцээ амьдралаас урган гарчээ. Харин ноос, ноолуур, хөөвөр нь байгальд өөрөө 100% задардаг учраас байгальд ээлтэй, хаягдалгүй ширхэгт юм.

"Дулаан Сэтгэл" брэндийн бүтээгдэхүүн бүрт Монгол малчин хүний хөдөлмөр, гар урлаачдын сэтгэл шингэсэн байдаг учраас таныг болон таны хайртай хүмүүсийг "дулаан" байлгаж байгаль эхдээ ч ээлтэй байх боломжийг олгоно.

өвөртөлжээ. Улмаар тэд гар урлалыг дэмжих хүсэлдээ хөтлөгдөн "Арт Эсприт Монгол" компанийн үйл ажиллагааг дэмжин бүтээгдэхүүнийг нь Франц төдийгүй Швейцар улсад борлуулж тогтвортой хамтран ажиллаж байна. Өдгөө тус компанийн үйл ажиллагаа нь өргөжиж зөвхөн гадагшаа экспортлох бус 2018 оноос дотоодод "Дулаан Сэтгэл" (Warm Heart) брэндийг "Эрхэм Монгол хүн та Дулаан Яваарай" уриан дор бий болгожээ. Тус брэнд сарлагийн хөөвөр, тэмээний ноос, хонины ноосон дулаахан, чанартай бүтээгдэхүүнийг урлаж байна.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД БОРЛУУЛАЛТАА ӨСГӨЖ, АЖЛЫН БАЙРАА НЭМЖЭЭ

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас салбар бүрийн үйлчилгээ, борлуулалт, бизнесүүд амаргүй байдалд орсон билээ. Гэвч "Дулаан Сэтгэл" брэндийн ажилчид ихэвчлэн гар урлаачид, гэртээ цехтэй хүмүүс байдаг учраас цар тахлын үеэр ч гэрээсээ ажиллаж орлого нь тасраагүй ажээ. Цар тахлын хажуугаар шинэ боломжийг эрэлхийлэн хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлснээр борлуулалт нь өсчээ. Мөн тус салбарыг зарим хүмүүс улирлын шинж чанартай гэж эндүүрдэг. Гэвч намар, өвлийн улиралд дотооддоо борлуулалт хийж, хавар, зундаа гадны худалдан авагчдын захиалгыг бэлтгэдэг тул жилийн 4 улиралд үйл ажиллагаа нь тасалдахгүй ажилладаг аж.

Д.УРАНЧИМЭГ: МАНАЙХ ЖИЖИГ Ч ГЭЛЭЭ ТОМ АМБИЦТАЙ КОМПАНИ

Бид дулаахан, чанартай бүтээгдэхүүнээр дамжуулан 70 гаруй сая малтай Монгол улсаа гадныханд сурталчлан Монгол ахуй, соёлыг гар урлалдаа шигтгэн тэдэнд таниулах, эскпортын үр шимээр улсынхаа валютын урсгалд жаахан ч гэсэн хувь нэмрээ оруулах, гар урлаачдыг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой. Өргөн уудам газар нутагтай, арвин баялагтай манай улс өөрсдөө үйлдвэрлэж, бүтээж л чадвал цөөхөн Монголчууд бид эх орондоо сайхан амьдрах боломжтой билээ. 100% хонины ноос, сарлагийн хөөврөөр урласан бүтээгдэхүүн таны бие мөн сэтгэлийг ч дулаацуулна.

Сарлагийн хөөвөр нь бусад ноосоос 23 хувь илүү дулаан, бат бөх байдаг бөгөөд байгальд ээлтэй ширхэгт гэдгээрээ Европын хэрэглэгчдийн сонирхлыг илүү татаж байна. Бүтээгдэхүүн бүрийг сэтгэлээ шингээж урладаг учраас тус брэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэхдээ хүмүүс тааламжтай байдаг.



"Дулаан сэтгэл" брэнд: Тал шигээ уудам сэтгэлтэй Монгол хүний "Дулаан Сэтгэл" шингэсэн бүтээгдэхүүнүүд дэлхийн өнцөг булан бүрт хүрээсэй гэж бид хүснэм...



БОЛОВСРОЛ

МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРТ НЭГЭН
ШИНЭ ӨНГӨ ТӨРХИЙГ БИЙ БОЛГОЖ БУЙ

ТОМҮО АППЛЕЙКШН

Нийт хэрэглэгчдийн тоо: 200,000 цаашдаа энэ тоог НЭГ саяд хүргэх зорилготой.

Хэрэглэгчдийн насны бүлэг: 14-20 нас бөгөөд тэд энэ хүрээг тэлж хүн бүрийг насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа юм.

ТЭДНИЙ ТОМҮО-Г ҮҮСГЭН БАЙГУУЛСАН ШАЛТГААН БОЛ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛОВСРОЛЫГ БИЙ БОЛГОХ

TomYo-г үүсгэн байгуулагч В.Баярсайхан нийгэмд болж буй суурь асуудлыг шийдэх хамгийн энгийн гарц бол боловсрол эзэмших гэж үздэг бөгөөд улсынхаа боловсролын хүртээмжийн асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй байв. Улмаар Дорнод аймагт суурь боловсрол эзэмшээд, Вашингтоны Их Сургуулийг төгссөн өөрийн туршлагаасаа урам авч хотын захын дүүрэг, хөдөө орон нутгийн хүүхдүүдэд боловсролыг тэгш хүртээж, боломжийг нээж өгөхийг хүсжээ. Ердөө нэг хүний хүсэл мөрөөдлөөс бий болсон уг компани өдгөө 30 ажилтантай бүтээлч, эрч хүчтэй баг болж чаджээ.

"BLUE STARTUPS" ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨРТ ТЭНЦСЭН АНХНЫ МОНГОЛ КОМПАНИ

"TomYo"-ийн Стратеги хариуцсан захирал

О.Энхжин: "TomYo" нь Монгол оюуныг дэлхийд түгээх зорилготой. Ингэхдээ компанийн хувьд ч гэсэн олон улсын түвшинд гарч тэдний жишгээс суралцах нь чухал. Нэг сарын өмнө бид олон улсын хэмжээнд гарах том давааг давж, анхны америк хэрэглэгчдэдээ үйлчилгээгээ үзүүлээ. Манай хамт олон "Blue Startups" хурдасгуур хөтөлбөрт оролцон 500 гарааны бизнесүүдээс шигшигдэж тэнцсэн анхны Монгол компани болсон. Энэхүү хурдасгуур хөтөлбөрөөс Airbnb, Uber том компаниуд гарсан байдаг. Бид эдгээр томоохон компаниудын мөрөөр дэлхийн түвшний компани болохыг хүсэн тэмүүлж байна.

ДИЖИТАЛ ХЭЛБЭРЭЭС БОДИТ БИЗНЕС "ТОМҮО KIDSClub" СУРГАЛТЫН ТӨВ

О.Энхжин: TomYo байгуулагдаад жил хагасын дотор дижитал хэлбэрээс бодит бизнес хэлбэрт шилжин "TomYo KidsClub" сургалтын төвөө байгуулсан. Үүний шалтгаан нь боловсролыг зөвхөн технологи хэлбэрээр шийдэх нь буруу, тэгш хүртээмжтэй боловсролд хүрэхийн тулд технологи болон уламжлалт сургалтыг хослуулж явах ёстой гэдэг шийдэл байв. Цаашдаа бид 2022 онд "TomYo School of Ulaanbaatar" гэх ерөнхий боловсролын 1000 хүүхдийн багтаамжтай сургууль байгуулахаар барилгын ажлаа эхлүүлсэн. Мөн энэхүү сургуулийн сурагч мөн эсэхээс үл хамааран сургуульд заагдах танхимын хичээлийг "TomYo" апп дээрээс үзэх боломжтой моделийг хөгжүүлэхээр ажиллаж байна.



Стратеги хариуцсан захирал
О.Энхжин

"TomYo" нь богинохон хугацаанд гаргасан амжилт ололтоороо өөрийн боломж боллоцоо, хэтийн төлвөө тодорхойлон харуулж чаджээ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээхэн татаж байгаа нь илт байна. Манай уншигчид танай компанид хөрөнгө оруулалт хийх ямар боломж байгаа талаар хуваалцвал?

"TomYo" компани нь санхүүгийн хувьд бие даасан, зах зээлд танигдсан төдийгүй брэндийн хувьд үйлчлүүлэгчид нь тогтчихсон. "TomYo Kidsclub" болон "TomYo School of

Ulaanbaatar" нь нийгмийн асуудлыг шийдэх боловсролд чиглэсэн олон төслүүд хэрэгжүүлдэг. Үүний нэг жишээ бол "TomYo Impact" төсөл. Энэ төслийн хүрээнд манай баг олон зүйл хийхийг зорьж байна. Юуны түрүүнд нөөц бололцоо ихтэй ч санхүүгийн асуудлаа шийдэж чадаагүй залууст "TomYo Тэтгэлэг" гаргах, хөдөө орон нутагт олон нийтийн төвүүдийг дэмжих гэх мэтчилэн том төслүүд хэрэгжүүлэх экосистем бүрдүүлж байна. "TomYo Impact" болон монгол оюуныг дэлхийд хүргэх зорилт руу чиглэсэн том төслүүд дээр хөрөнгө оруулалт хийхэд "TomYo"-ийн зүгээс бүрэн нээлттэй.



ТЭДНИЙ БУСАД БОЛОВСРОЛЫН ПЛАТФОРМУУДААС ЯЛГАРАХ ОНЦЛОГ БОЛ: НАСАН ТУРШИД СУРАЛЦАХ БОЛОМЖООР ХАНГАХ

Өдгөө үйл ажиллагаа явуулж буй боловсролын технологийн компаниуд нь тодорхой бүлгийн зорилтот зах зээлд үйлчилдэг байх нь түгээмэл. Харин тэд нас, хүйс үл хамааран ямар ч зорилготой байсан TomYo аппликейшныг ашиглан насан туршдаа хөгжих, суралцах боломжоор хангажээ.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД

Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан дэлхий даяар цахим хувилбар луу шилжсэн. Өмнө нь бага, дунд, дээд боловсролыг хүн цахимаар авна гэдэг ойлголт бараг л байгаагүй. Харин "TomYo" цар тахлаас урьтаад шийдлийг нийгэмд санал болгогчлоод байсан нь нийгэмдээ оруулсан үнэ цэн юм.

Дэлхий өөрөө их завгүй, маш хурдтай хувьсаж өөрчлөгдөхийн хэрээр хүн өөрийгөө хөгжүүлэх цаг зав болон санхүү хомс болсоор. Харин тэд үйлчлүүлэгчдэдээ асар хямд үнээр өөртөө ур чадварыг бий болгож үүгээр өөрийн үнэ цэнээ нэмэхэд нь тусалдаг. Цаг хугацаа, орон зай үл хамааран интернет болон ухаалаг төхөөрөмжтэй л бол та хямд үнээр бүх зүйлийг сурах боломжтой. Хүртээмжтэй байх үүднээс хичээлүүд нь чанартай бөгөөд үнийн хувьд 8900 – 69000 хооронд байдаг. Учир нь "TomYo" аппликейшнд хичээлээ оруулдаг

багш, менторууд "TomYo"-ийн алсын хараа, зорилтот итгэдэг, олон залуусыг амжилт өөдөө дагуулна гэсэн хүсэл эрмэлзэл доор нэгдэж чаддаг учир хямд байдаг.

Хямд бөгөөд чанартай боловсролыг сургууль, сургалтын төвөөр хязгаарлахгүй санал болгож байгаа нь нийгэмдээ цар тахлын хэцүү үед бий болгосон хувь нэмэр болжээ.

ОЙРЫН ХУГАЦААНД "ТОМЮО"-ООС БИД ЯМАР СОНИРХОЛТОЙ ЗҮЙЛИЙГ ХҮЛЭЭЖ БОЛОХ ВЭ?

1. Бид хэрэглэгчдэдээ хамгийн хялбар, минимал дизайныг санал болгох шинэ апп хувилбараа саяхан танилцуулсан.
2. Удахгүй TomYo Community буюу бие биенээсээ суралцах холбоог өргөжүүлнэ.
3. Аппликейшны нээлтийг тохиолдуулан "Нэг эрх, нэг мөрөөдөл" төслийн хэмжээнд тэгш хүртээмжтэй боловсрол руу одоо илүү эрчтэй орж байна. Энэ төслөөр "TomYo" аппликейшны хичээлийн эрхийг худалдан авах чадвартай нэгэн өөрийгөө хөгжүүлэхийн сацуу өөр нэг залууд дахин тэр эрхийг бэлэглэх юм. Ингээд бид 1000 эрхийг орон даяар тархсан эрдмийн элч нараараа дамжуулан 1000 залууст бэлэглэж "TomYo Community"-д нэгтгэн нөлөөллөө бий болгох юм.
4. Орон нутагт бид нийгэмд хүртээмжтэй байхын тулд "Гадаадад сурах гарц" нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэхээр өнгөрсөн жил зүүн таван аймгаар тойрсон бол энэ жил баруун зургаан аймгаар тойрох төлөвлөгөөтэй байна.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ АНХНЫ НЭГ ИХ НАЯДЫН ҮНЭЛГЭЭТЭЙ КОМПАНИА ӨЛГИЙДӨН АВЛАА

Эх сурвалж: Монцамэ

Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсэж хөгжөөд 30 жилийг ардаа үлдээжээ. 2021 оны хувьд хөрөнгийн зах зээлд олон шинэ үйл явдлууд болж хөдөлгөөн ихтэй, онцлох жил болж байна.

2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны 1-р улирлын байдлаар 3.7 их наяд байсан бол 3-р улирлын дунд үеийн байдлаар түүхэндээ хамгийн өндөр үнэлгээ болох 4.8 их наяд буюу 29.7%-р өссөн үзүүлэлттэй байна. Монголбанкнаас Ковид-19 цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөг

бууруулах, эдийн засгийн сэргэлтийг дэмжиж зорилгоор бодлогын хүүг 2020 оны 11 сард 6 хувь болгох шийдвэр гаргаснаар хадгаламжийн хүү буурсан мөн Ковид-19 цар тахлаас үүдэн арилжааг цахимаар хийдэг болсон нь иргэдийг үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцох шалтгаан болж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ МАШ ӨСӨЛТТЭЙ ЖИЛ БОЛЛОО



ХУВЬЦАА



Шингэн хүнсний ууган үйлдвэр “АПУ” ХК нь Монголын хөрөнгийн бирж дэх

1 ИХ НАЯДЫН ҮНЭЛГЭЭТЭЙ АНХНЫ КОМПАНИ

компанийн хагас жилийн борлуулалт өмнөх оны хагас жилээс

35% ХУВИАР ӨССӨН

цэвэр ашгийн хэмжээ

80% ХУВЬ ӨССӨН



TenGerLeague Media Group

MSE: TNGR

АНХНЫ НЭЭЛТТЭЙ МЕДИА ГРУПП БАЙГУУЛАГДЛАА

“Монгол ТВ” телевиз, “Промедиа Нетвөрк” буюу “VTV” телевиз, “Unread Media” гэсэн гурван компани нэгдэн “ТэнГэрЛиг Медиа Групп (TenGerLeague Media Group)” гэх

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН АНХНЫ НЭЭЛТТЭЙ КОМПАНИ БАЙГУУЛАГДАВ.

ТМГ нь Монголын Хөрөнгийн Бирж дээр үйл ажиллагаа явуулдаг “Е-Моние” ХК-тай урвуу нэгдэл (RTO) хийх замаар нээлттэй компани болох ба ингэснээр үйл ажиллагаа нь ил тод нээлттэй болж олон нийт хяналт тавих, өгөөж хүртэх боломжтой болох юм.



МХБ-ийн бүртгэлтэй компаниудаас үйл ажиллагаа, ашиг орлого, арилжааны идэвх, компанийн засаглалаараа тэргүүлэгч компаниудыг хамруулсан

I дүгээр ангилалд

**“АРД КРЕДИТ ББСБ” ХК
“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК
“ИНВЕСКОР ББСБ” ХК**-иуд

шинээр дэвшин орсон бол бүртгэлийн

II дугаар ангилалд

**“ЭРДЭНЭ РЕСУРС
ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН”
“ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ” ХК**

зэрэг компаниуд шинээр орлоо.

БОНД

“Эрдэнэс Тавантолгой” ХК өнгөрөгч 4 дүгээр сард томоохон төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор

Монголд анх удаа нийт

2 ИХ НАЯД ХҮРТЭЛХ
төгрөгийн дүн бүхий
ТӨГРӨГ, ВАЛЮТ ХОСОЛСОН
ЭТТ БОНДЫГ

гаргах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авсан.

ЭТТ бондыг 3 үе шаттайгаар олон нийтэд санал болгохоор төлөвлөсөн бөгөөд эхний үе шатыг 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 9-ний өдрүүдэд зохион байгуулсан юм.

Харин хоёр дахь шатны 2021 оны наймдугаар сарын 25-ны өдрийн II шатны нэгтгэсэн дүнгээр 519.4 тэрбум төгрөг, 53.1 сая ам.долларын захиалгыг хийж анхны төлөвлөсөн хэмжээг 117%-ийн захиалгын хувьтайгаар давуулан биелүүлэв. (ЭТТ “Таван Толгой” Хувьцаат Компани 100\$-ын 5.8%-ийн хүүтэй долларын бонд, 100,000-ийн нэрлэсэн үнэтэй 10%-ийн хүүтэй бонд)

Монголын хөрөнгийн зах зээлд анх удаа

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙГ
нээх цан цохих ёслолын үйл ажиллагаа

болсон ба Голомт Капитал ҮЦК анхны биржийн бус зах зээл/OTC market/ дээр 15 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Монкон бондын захиалгыг 8 өдрийн дотор амжилттай биелүүллээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХК нь хөрөнгийн зах зээл дээр 06.30-08.05ны хооронд буюу дөрвөн 7 хоногт 50 тэрбумын хөрөнгө оруулалтыг анхдагч зах зээл дээр

амжилттай босгосон ба 7000 хөрөнгө оруулагч нэгдсэн **МОНГОЛЫН ХОЁРДОГЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН** болов.

МИШЕЛЬ БОРОК: МОНГОЛ БОЛ АМЬДРАХАД ГАЙХАЛТАЙ АМАР АМГАЛАН УЛС



Монгол Улс гадаадын иргэн амьдрахад хэр таатай, амар тайван улс вэ? гэдэг асуултын хариултыг өгөхөөр МҮОНРТ-ийн англи хэл дээрх сувгийн редактор Мишель Бороктой ярилцлаа.

Юуны өмнө бидний урилгыг хүлээж авсан танд баярлалаа. Та бидэнд өөрийгөө танилцуулж, юу таныг Монголд авчирсан тухай хуваалцаж болох уу?

Намайг Мишель Борок гэдэг. Би Миннесотагийн их сургуулийг төгссөн. МҮОНРТ-ийн англи хэлний суваг үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш редактороор ажиллаж байна. Анх 2010 онд амралтаараа морин аялал хийж болох газруудыг онлайнээр судлахад Монгол гарч ирсэн. Тэгээд найзтайгаа Тэрэлж рүү найм хоногийн морин аялалд гарсан. Тэр аяллын үед Монголын онгон байгаль, амар амгалан, сэтгэлийн баяр баясгалан гээд л төсөөлж байгаагүй зүйлсээ харж, мэдэрсэн. Аялал маань надад үнэхээр их таалагдсан. Хамгийн олзуурхуштай нь тэр аяллын үеэр нөхөртэйгөө танилцсан. Бид одоо Дархан хотод хамтдаа аз жаргалтай амьдарч байна.

Таны хувьд хамгийн их таалагддаг, бусадтай хуваалцахыг хүсдэг монгол ахуй, соёл бий юу?

Монгол соёлын хамгийн их таалагддаг зүйл бол өгөөмөр сэтгэл, гэр бүлийн үнэ цэн юм. Намайг энд ирэхэд хадмууд маань намайг шууд л өөрийнхөө охин мэт халуун дулаанаар угтаж авсан. Хөдөө явж, малчин айлд очиход мэдрэгддэг монголчуудын нэг тийм халуун дулаан сэтгэл бий. Хэн нэгнийд зочлоход эхлээд суух сандал, халуун сүүтэй цай өгөөд дараа нь хоол хийж өгдөг. Ийм өгөөмөр сэтгэл орчин үед ховор, үнэ цэнтэй. Мөн хамаатан саднууд хоорондоо холбоотой байж, ойр

дотно байдлаа дээдэлж, хадгалдаг нь үнэхээр гайхалтай санагддаг.

Таны ажил, мэргэжлийн талаар ярилцъя. "MNB World" телевизэд ажиллахад танд хамгийн их таалагддаг зүйл юу вэ?

Миний хийдэг ажил надад маш их таалагддаг. Би сэтгүүлчдийнхээ бичсэн текст, орчуулга, сурвалжилга зэргийг редакторлаж, англи хэл дээрх текстийг засварладаг. Ажил маань өргөн цар хүрээний мэдлэг олгодог болохоор Монгол Улс хаашаа явж байгааг ерөнхийдөө харж болдог. Ихэвчлэн хилийн чанадад амьдарч буй уншигчдад дотоодод болж буй үйл явдал, өөрсдийн соёлын тухай бяцхан түүх ч байсан хургэхэд тусалж байгаа нь надад таатай байдаг.

Монгол дахь амьжиргааны зардлын талаар та юу гэж бодож байна вэ? Монголд амьдрах нь АНУ-д амьдарч байснаас хэр ялгаатай байдаг вэ?

Миний эргэн тойронд сувилагч, асрагч, малчин, төмөр замын ажилчид зэрэг хүмүүс байдаг болохоор мөнгө олох хэчнээн хэцүүг би сайн мэднэ. Хэрвээ Америкт амьдарч байсан бол одоо амьдардаг байшин шигээ байшинд амьдрах байсан болов уу гэдэг эргэлзээтэй. Гадаадаас орж ирэх тогтмол орлоготой бол төгрөг рүү шилжүүлэхэд боломжийн мөнгө болдог. Миний ажлын нэг онцлог нь орлого олох боломж арай өндөр байдаг. Одоогоор манай охин гадаад багш нартай, нэг ангид цөөн тооны хүүхэдтэй, сургалтын чанар сайн гэгдэх хувийн сургуульд сурдаг. Тиймээс энд ямар их давуу тал, боломж байгааг мөн эдгээрийг гэр бүлтэйгээ хуваалцах боломжтой байгаадаа их талархаж явдаг.





Гадаадын иргэний хувьд Монголд төрийн үйлчилгээг авах нь хэр хялбар байдаг вэ?

Сүүлийн жилүүдэд Засгийн газар үйлчилгээгээ илүү хүртээмжтэй болгохын тулд олон том өөрчлөлтүүд хийж байна. Англи хэлээр илүү олон хууль, дүрэм журмууд орчуулагдсан. Энэ нь редактор хүний хувьд хийж буй ажлынхаа тухай хууль тогтоомжийг судалснаар ажлыг минь их хөнгөвчлөгдсөн шүү. Мөн гадаадын оршин суугчдын эрх зүйн байдлын тухай шинэ хууль тогтоомж, цагаачлалын газрын үйлчилгээнд өөрчлөлт орсон нь эерэг үр дүн авчирсан. Төрийн бүх үйлчилгээ нийслэл хотод төвлөрсөн тул хотод амьдардаггүй гадаадын иргэдэд онлайн үйлчилгээ үнэхээр тустай.

Өмнө нь би оршин суух үнэмлэхээ сунгуулахаар Улаанбаатар хот уруу 3-7 цаг машинаар явж очиход цагаачлалын газрын ажлын цаг дууссан байдаг тул тэндээ хоноод өглөө очих хэрэгтэй болдог байлаа. Одоо би эдгээрийг цахимаар хийх боломжтой болсон. Энэ бол асар том өөрчлөлт гэж боддог.

Мөн дутагдаж байгаа зүйл ч олон бий. ТҮЦ машинд жолооны үнэмлэх, нийгмийн

даатгалын төлбөр гэх мэт надад хэрэгтэй үйлчилгээнүүд байдаг ч энэ нь монгол хүмүүст зориулсан байдаг. Азаар надад монгол найз нөхөд, тусалж чадах хүмүүс зөндөө байдаг болохоор асуудал гардаггүй. И-баримтын систем надад үнэхээр гоё санагддаг, иргэд татвараа төлөхдөө дургүйцэхгүй харин ч И-баримтын тохирлыг хүлээж догдолдог. Удахгүй дахиж ямар өөрчлөлтүүд гарахыг хармаар байна шүү.

Та МУ-ыг хэр аюулгүй улс гэж боддог вэ? Танд ямар нэгэн аюул заналхийлэл таарч байсан уу?

Монгол бол гайхалтай тайван улс. Саяхан хичээлийн шинэ жил эхэлж би охиноо энэ цар тахлын дунд үед сургуульд явуулахаар боллоо. Сургуулийн бүх багш, ажилчид, хүүхдүүдийн эцэг эх, 12-оос дээш насны сурагчид бүгд дархлаажуулалтад хамрагдсан, маскаа тогтмол зүүдэг болохоор надад айх айдас байгаагүй. 9 дүгээр сарын 1-нд хичээлдээ явж эхлэхэд миний охины коронавирусийн халдварт өртөх эрсдэл нь АНУ-д буй найз нөхдийн маань хүүхдүүдтэй харьцуулахад маш бага. Монголд Америк шиг маск зүүх үгүй нь улс төрийн асуудал болоогүй, вакцин хийлгэх

хийлгэхгүй тал дээр амиа хичээсэн үзэл байдаггүй. Энэ Монгол Улс хэчнээн аюулгүй орон болохыг харуулж чадна гэж бодож байна. Би охиноо ийм амар тайван орчинд өсөж байгаад дотроо баярлаж явдаг.

Ярилцлагынхаа төгсгөлд танд уншигчидтай маань хуваалцмаар байгаа зүйл байна уу? Монголд амьдрахыг хүсэж буй гадаадынханд хэлэхийг хүссэн зүйл ч юм уу?


Аливаа ярилцлагын хамгийн хэцүү хэсэг нь үргэлж л төгсгөлийн үг байх юм даа /инээв/. Хүн бүр л гэр бүл, бие болон сэтгэцийн эрүүл мэндээ эрхэмлэдэг. Хэрэв та барууны орноос, эсвэл Азийн бусад орноос ирсэн бол эндхийн өдөр тутмын амьдрал төлөвлөсөн шиг өнгөрөхгүй байж мэдэх юм. Хүнд аливааг хийх тусгай цаг хугацаа, газар гэж байдаг гэдгийг санаад ямар нэг зүйл болохгүй байвал нэг их бухимдахгүй, хүлээлтээ өөрчлөөрэй гэж хүсэх байна.

Цаг зав гарган ярилцлага өгсөнд баярлалаа. Танд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе!

Баярлалаа.



INVEST IN MONGOLIA


 Засгийн газрын 2-р байр, Нэгдсэн
Үндэстний Гудамж, Улаанбаатар 15160

 www.nda.gov.mn

 [/investmongolgov](https://www.facebook.com/investmongolgov)

 [/ndagovMN](https://twitter.com/ndagovMN)

 info@nda.gov.mn

 976-51-261589, 7777 8787

investmongolia.com



Empowering The Economic Development Of Mongolia